

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

*Д. Энхчимэг**
*Т.Мөнх-Оргил***

Хураангуй: Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэгддэг. Монгол Улсын БХЭЗЧ-ын үзүүлэлтүүдийн нэг болох санхүүгийн чадавхын нөөц боломжын тухай авч үзлээ. Дэлхийн олонх улс оронд зэвсэгт хүчний шинэчлэл аюулгүй байдлын төлөв хандлагатай уялдан хурдацтай өөрчлөгдөж байна. Ийм нөхцөл байдалд улс орон бүр дотоодын нөөц бололцоогоо эрчимтэй ашиглах арга замыг эрэлхийлж байгаа өнөө үед цэрэг эдийн засгийн тоон шинжилгээ хийж батлан хамгаалах салбарын төсвийн санхүүжилтын төлөвлөлтийг тодорхойлов. Тайван цагт дунд хугацаанд БХЭЗЧ-ыг санхүүгийн механизмаас гадна эдийн засгийн бус арга замаар сайжруулах нь илүү үр дүнтэй шийдэл болно.

Түлхүүр Үг: Батлан хамгаалах эдийн засгийн чадавх (БХЭЗЧ), батлан хамгаалах эрх ашиг, Эдийн засгийн аюулгүй байдал (ЭЗАБ), цэргийн төсвийн зарцуулалт.

Судалгааны Хамрах Хүрээ: Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг сайжруулахад санхүүгийн чадавхын үүрэг роль чухал болохыг нотлон харуулав.

* Д. Энхчимэг ҮБХИС-ийн АБС-ийн багш, доктор (ph.d)

** Т.Мөнх-Оргил БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд хурандаа

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

УДИРТГАЛ

Батлан хамгаалах эдийн засгийн чадавх (БХЭЗЧ) -ын тухай ойлголтыг авч үзэхийн тулд “чадавх” буюу “potential” гэдэг үгийн агуулгыг авч үзвэл чадавх, чадамж, боломж, бололцоо гэсэн үг бөгөөд потенциал гэдэг нь аливаа салбарт байгаа боломж хэрэгслийн цогц. Тухайлбал, улс орны батлан хамгаалах эдийн засгийн чадавх. Энэ нь тайван цагт болон дайн байлдаан явуулахад хэрэгцээтэй эдийн засаг, улс төр, сэтгэлзүйн болон цэргийн нөөц боломжийн цогц юм.

Батлан хамгаалах эдийн засгийн чадавх гэдэг нь аливаа улс орны улс төр, батлан хамгаалах зорилтыг шийдвэрлэх зорилгоор улсын эрх ашигт ашиглагддаг, ашиглаж болох эдийн засгийн чадавхын бүрэлдэхүүн хэсэг нь юм. БХЭЗЧ нь улс орны тайван цагийн болон дайны үеийн эдийн засгийн хангалтад түүний дотор ЗХ-ний хэрэгцээнд хүрэлцэхүйц цэргийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн боломжит дээд хэмжээний цогц ойлголт юм.

БХЭЗЧ нь улс орны улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийн төвшин, шинжлэх ухаан, технологи, инновацийн менежмент зэргээс хамаарч тэдгээрт тулгуурлах нь тодорхой байна. ЭЗАБ, батлан хамгаалах ашиг сонирхол чадавхад нөлөөлөх зүй тогтлыг дараах байдлаар авч үздэг. БХЭЗЧ-д нөлөөлөгч дотоод, гадаад хүчин зүйлс:

А. Дотоод хүчин зүйлс:

- Улс төрийн хүчин зүйл (улс төр, засаглалын чадавхи)
- Нийгэм соёлын хүчин зүйлс (түүх соёлын уламжлал, шашин шүтлэг)
- Эдийн засгийн хүчин зүйлс (уламжлалт аж ахуй, олон талт эдийн засгийн бүтэц, үйлдвэрлэх хүчний хөгжил, эдийн засгийн субьектүүдийн харилцаа)
- Хүн амын өсөлт (хүн амын тоо, чанар, боловсрол, хүмүүжил, төлөвшил, эх оронч үндэсний үзэл, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний мэргэжлийн чадвар, дайчилгааны нөөц)
- Шинжлэх ухаан, технологийн хүчин зүйл (технологи дамжуулалт, нутагшуулалт, эзэмшилт, шинэ технологи зохион бүтээх, хуучныг шинэчлэн сайжруулах инноваци)
- Байгаль экологийн хүчин зүйл (байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, цаг агаарын уур амьсгал) зэргээр нөхцөлдөнө.

Б. Гадаад хүчин зүйлс:

- Төлбөрийн тэнцэл, гадаад эдийн засгийн хамтын ажиллагаа,
- Олон улсын валют санхүүгийн харилцаа,
- Гадаад улс орон, олон улсын байгууллагаас хэт их өрийн дарамтад орох,
- Стратегийн ач холбогдолтой экспортын бүтээгдэхүүний өөрчлөлт, стратегийн ач холбогдолтой салбарт гадаадын хөрөнгө оруулагчийн нөлөө өсөх зэрэг болно.

Улс орны батлан хамгаалах эдийн засгийн чадавхын төлвийг нийгэм, улс төрийн тогтвортой байдал, улс гүрний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, гадаад ба дотоод аюул заналхийллийн нөлөөллийг эсэргүүцэх чадвар, нийгэм эдийн засгийн байдалд тэсвэртэй байх чанар, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж байгаа байдал зэрэг үнэлэмжээр тодорхойлж болох юм.

Аливаа улс орныг батлан хамгаалах ямар ч хувилбар байсан энэ нь зөвхөн эдийн засгийн боломж чадавхаас хамаарч түүнд тулгуурлах болно. Мөн улс орны эдийн засгийн хэвшилд гарсан хувьсал, өөрчлөлт нь БХЭЗ-ийг бүрдүүлэн бэхжүүлэх арга замыг шинэчлэх үндэс болжээ.

Улс үндэстний батлан хамгаалах эрх ашигт заналхийлэх утгаар нь ажилгүйдэл, ядуурал, төсвийн алдагдал, анагаагдах онош нь тодроогүй элдэв өвчин тахлын тархалт, мансууруулах бодис, зэвсгийн наймаа, цөмийн болон үй олноор хөнөөх зэвсэг, бусад зэвсэг, тийм хөнөөх хэрэгсэл, үйлдвэрлэх нууц алдагдах, олон улсын терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, байгаль экологийн сүйрэл зэргийг аюул заналд тооцон ойлгодог.

Монгол Улсын эдийн засгийн бодлого, төлөвлөлт, стратегийн ач холбогдолтой уул уурхай, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, гадны хөрөнгө оруулалт, ажиллах хүчийг ашиглах үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлж байна¹.

Эдийн засгийн хямрал, хүнсний бүтээгдэхүүний чанарын асуудал, үнийн өсөлт, тэрчлэн гадаад ертөнцтэй холбосон нийгэм эдийн засгийн хамтын ажиллагаа, хүрээлэн буй орчны асуудал зэрэг нь сэтгэл түгшээж

¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт, "Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс"

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

байгаа нь аюулгүй байдлын цэргийн бус хүчин зүйлд нухацтай анхаарахыг шаардаж байна.

Батлан хамгаалах эрх ашиг, ЭЗАБ, БХЭЗЧ-т нөлөөлөх үндсэн хоёр хүчин байна. Нэгдүгээрт, үндэсний эдийн засгийн хөгжлийн төвшин, өрсөлдөх чадвар, хоёрдугаарт, дэлхийн олон улсын зах зээл дээр эзлэх байр суурь, улс орнуудын өрсөлдөөний төвшин юм. Өрсөлдөх чадвар нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндсэн хүчин зүйл болдог. Хөгжлийн тогтвортой байдлаа хадгалахын тулд аль ч орон дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байж байр сууриа бэхжүүлэх шаардлагатай. БХЭЗЧ-ын үзүүлэлтийг босго утга, гадаад, дотоод хүчин зүйлээр үнэлж дүгнэнэ. Иймд ЭЗАБ, БХЭЗЧ-ыг хангахын тулд дэлхий нийтийн хөгжлийн хандлага, тухайн орны өвөрмөц онцлог харьцангуй давуу талд тулгуурласан стратеги, тактик, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.

Өнөөдөр манай БХЭЗЧ-ийн хүрээнд дараах нийтлэг эрсдлүүд бий болоод байгаа билээ. Үүнд:

- Улс төрийн тусгаар тогтнолоо олж авсан боловч эдийн засгийн тусгаар тогтнолоо олж авч чадаагүй;
- Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортоос хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон;
- Байгалийн баялаг, гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналт алдагдсан; үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон;
- Геополитикийн шинэ эрсдэл бий болсон. Энд дэлхий дахинаа эдийн засгийн өрсөлдөөн сөргөлдөөний хэлбэрт орж Монгол Улс байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөний талбар болсон;
- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихдээ төрийн зохицуулалтыг алдагдуулж үйлдвэрлэлийн үндсэн фондыг өмч хувьчлалаар үрэгдүүлэн доройтуулсан;
- Эдийн засгийн бие даасан байдал хангагдаагүй, стратегийн хүнс, бараагаар өөрийгөө хангаж чадахгүй, гадаад зах зээл, ялангуяа хөрш орнуудаас ихээхэн хамааралтай хэвээр байгаа;
- Үнийн өсөлтөд өртөмтгий, хэт өрөөсгөл, эмзэг бүтэцтэй хэвээр байгаа;
- Хүнд суртал, авилга, монополь ноёрхсон бизнес, шударга

өрсөлдөөн, хөрөнгө оруулалтын орчин эрүүл биш зэрэг болно.

Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэнэ².

Төсвийн зардлыг ангилах нь чиг үүргээр зардлыг хуваарилах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, зориулалтын дагуу зарцуулж байгаад хяналт тавих, түүнчлэн цэргийн зардлын хэмжээ, бүтцийн хувьд харьцуулан шинжлэх боломж олгож, төсвийн санхүүжилтийн ерөнхий тогтолцоонд ихээхэн үүрэгтэй байдаг бөгөөд цэргийн зардлын ангиллын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, практик хэрэгцээнд нийцүүлэх боломж олгодог байна.

Дэлхийн улсуудын батлан хамгаалахад гарч буй өөрчлөлтүүд, шинэ чиг хандлагууд нь иргэний ардчилсан, хүмүүнлэг нийгэмд батлан хамгаалах салбарын гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг шинээр тодотгон тогтоож байна.

Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх асуудлын зорилго, зорилтууд, хугацаа, гүйцэтгэгч, нөөц, хуваарилсан санхүүгийн хөрөнгөөр бүхэлд нь нягт уялдуулсан цогц тогтолцоог бүрдүүлэх нь төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөвлөсөн санхүүгийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглахад нөлөө үзүүлдэг байна. Төсөвлөсөн санхүүгийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглахад ОХУ-ын “ зорилгот-хөтөлбөр-төлөвлөлт”-ийн аргыг хэрэглэх нь илүү үр дүнтэй гэж ойлгогдохоор байна. Учир нь энэхүү хөтөлбөр нь улс орны “хүчний ” бүтцүүдийн хэрэгцээг цогц байдлаар тодорхойлох, бүтэц, бүрэлдэхүүний тоог оновчтой болгох, илүү шат дамжлага, ажил үүргийн давхардал, үрэлгэн байдал зэрэг үйл ажиллагааны сөрөг үр дагаварыг арилгах урьдчилсан нөхцөл бүрдүүлдэг. Энэхүү *хөтөлбөрийн давуу тал нь* цэрэгт үзүүлэх дэмжлэг, батлан хамгаалах чадавхийг зохих түвшинд бий болгож чаддаг байна. *Батлан хамгаалах төсөв зохиох үйл явцыг боловсронгуй болгох зорилгоор* нэгд, цэргийн төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх олон талт түвэгтэй шинжийг агуулсан “үүрэг зорилт”, “ зардал”, “ санхүүжилт” гэсэн харилцан уялдаатай санхүүгийн үзүүлэлтийн тогтолцоог хэрэглэхэд шилжих, хоёрт, цэргийн төсвийн зориулалтыг хуульчлан сахих, гуравт, тайлан, бүртгэл тооцоо, зэвсэг,

2 Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

техникийн захиалга, цэргийн бүтээгдэхүүний үнэ бүрдэл зэрэг асуудлыг боловсронгуй болгох, дөрөвт, зах зээлийн нөхцөлд цэрэг-эдийн засгийн




1. дүгээр зураг.

Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлагын бүдүүвч.

Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлага нь нэгд, зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох, хоёрт, тавигдсан зорилгод хүрэх арга хэмжээг цогц байдлаар авч үзсэн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, гуравт, батлан хамгаалах төсвийг боловсруулах гэсэн хоорондоо нягт уялдаатай дараалсан гурван үе шатыг багтаах болж байна.

Цэргийн зардлын урт хугацааны санхүүжилтын төлөв байдлыг бусад улс орнуудынхтай харьцуулахад дараах байдалтай байгаа юм. Дунджаас доогуур орнуудынхаас манай улсын цэргийн зарцуулалт доогуур байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд дэлхийн батлан хамгаалах бодлого, хөгжлийн хандлага тэлж байгаа өнөө үед ядаж өөрийгөө хамгаалах чадавхитай байхын тулд цэргийн зарцуулалтын эрэлт нэмэгдэх шаардлагатай болж байгаа билээ. Дунджаас доогуур болон дээгүүр орлоготой улс орнууд тодорхой хэмжээгээр БХЭЗЧ-даа анхаарал тавьж байгаа нь энэхүү графикаас харагдаж байна. Тиймээс дунд хугацаанд биш юмаа гэхэд урт хугацаанд батлан хамгаалах бодлогын баримт бичигт тусгасан 2%-ийн хэмжээнд цэргийн зардлыг нэмэгдүүлэх бодлого баримтлах биш хэрэгжүүлэх хэрэгтэй.

3 Намсрай,Т. Нанжид,Д, “ Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал ”2016он, х121,
ISBN 978-99973-992-6-7.



Эх сурвалж: www.sipri.org.

2. дугаар зураг. Цэргийн зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ.

Дэлхийн олонх улс оронд зэвсэгт хүчний шинэчлэл санхүүгийн хатуу хязгаарлалтын нөхцөлд явагдаж байна. Улс орон бүр дотоодын нөөц бололцоогоо шаргуу эрэлхийлж байгаа өнөө үед цэрэг-эдийн засгийн шинжилгээ хийх, түүн дотор тоон шинжилгээ хийх аргыг хэрэглэх шаардлага тавигдаж байна.

Дунд хугацаанд (2017-2022 он) нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь хэмжээний доод хязгаар нь 0,7%-1,0%, дээд хязгаар нь 0,8%-1,3% байх шаардлагатай гэсэн тооцоолол гарч байгаа юм.

Үйл ажиллагаанд цэрэг-эдийн засгийн шинжилгээ хийсний үр дүнд нэгд, зэвсэгт хүчний бүтэц орон тооны зохион байгуулалтын үндэслэл, арга хэмжээний төлөвлөгөөний оновчтой байдал, тухай бүр нөөцөөр хангах байдал зэрэг үйл ажиллагааны зохион байгуулалтын түвшин, хоёрт, бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, материал хэрэгсэл, мөнгөн хөрөнгө зэрэг нөөцийн хэмжээ, гуравт, зэвсэглэл, цэргийн техникийн тактик-техникийн үзүүлэлт, цэргийн мэргэжилтнүүдийн тусгай бэлтгэлийн түвшин зэрэг нөөцийн хэмжээ, чанар, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны аргыг өөрчлөх замаар нөөцийг ашиглах янз бүрийн өгөөжит байдалд хүрч болох юм.

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

*Батлан хамгаалах салбар дахь төсвийн санхүүжилтийн
төлөвлөлтийн тооцоолол дараах байдалтай байна.*

1. дүгээр хүснэгт.

Д/д		Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	хувь	ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь	0,72	0,71	0,83	0,89	0,95	0,94
			0,79	0,78	0,88	0,94	1,15	1,30
2		Төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хувь	2,75	2,70	2,80	2,83	3,0	3,4
3	Зардлын ангилал (тэрбум төгрөг)	Урсгал зардал	265,80	269,70	270,85	273,45	280,95	295,91
4		Хөрөнгө оруулалтын зардал	158,75	160,05	165,13	169,40	181,30	185,45
5		Урсгал төсвийн хөрөнгөөр дайчилгааны нөөц бүрдүүлэх төсөөлөл	20,04	21,34	25,34	28,54	30,41	35,45
6		Хөрөнгө оруулалтын төсвөөр батлан хамгаалах нэгжүүдийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийн зардлын төсөөлөл	54,80	54,10	60,05	65,15	66,50	69,45
7		Цэргийн анги байгууллагуудын барилга байгууламжийг шинэчлэх зардлын төсөөлөл	24,95	25,80	29,50	30,05	32,50	34,50
8		Байнгийн бүрэлдэхүүн, хугацаат болон гэрээт ЦАХ-ын алба хаах таатай орчныг бүрдүүлэх зардлын төсөөлөл	21,50	23,60	24,55	26,51	29,55	30,10
9		Салбарын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардлын төсөөлөл	14,50	15,45	16,24	18,50	20,01	24,65

Судлаачийн тооцоолол.

Батлан хамгаалах нэгжүүдийн 2010-2016 оны гүйцэтгэлд үндэслэн экспоненциал динамик шинжилгээгээр дээрх зардлуудын прогнозыг таамаглав⁴.

Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд дунд хугацаанд (2017-2022 он) батлан хамгаалах салбарын төсвийн санхүүжилтийн төсөөллийг дээрх хүснэгтээр тооцон харууллаа. Санхүү нь мөнгөн хөрөнгийг дайчлах, нөөц хуримтлуулах, улсын цэрэг эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг талаас нь авч үзлээ. Өөрөөр хэлбэл цэргийн эдийн засгийн хэрэгцээ, зэвсэгт хүчний тайван цагийн бэлэн байдал, эсвэл дайны цагт санхүүжүүлэх асуудал нь БХЭЗЧ-аас хамаарна. Дэлхийн цэргийн хүчний зарцуулалт нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улсын батлан хамгаалах салбарын төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь хэмжээг 2%-3%-д, төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хувь хэмжээг 3%-5%-д тус тус хүргэх нь чухал болоод байгааг судалгааны ажлаараа харуулж байгаа юм.

Өнөөдөр манай улсын БХЭЗЧ-ыг сайжруулахад санхүүгийн чадавхын үүрэг роль чухал болохыг энэхүү судалгааны ажил нотлон харуулав. Тайван цагт дунд хугацаанд Монгол Улсын БХЭЗЧ-ыг сайжруулахын тулд эдийн засгийн ба эдийн засгийн бус арга замаар дайчилгааны болон цэргийн хэргийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана.

ДҮГНЭЛТ



4 Нямбат, Л, “ Эдийн засгийн хэмжилзүй” тэргүүн, дэд дэвтэр- аргууд, УБ хот, 2014 он, ISBN 978-99973-903-1-8.

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

Дээрх диаграммаас харахад ойрын жилүүдэд БХЭЗЧ-ыг санхүүгийн механизмаар сайжруулах арга замын тухайд боломж хязгаарлагдмал байгаа нь судалгаанаас илэрхий байна. (Хавсралт1. Эдийн засгийн эмзэг байдлын үзүүлэлт: 2016 оны байдлаар) Иймд БХЭЗЧ-ыг эдийн засгийн бус аргуудаар сайжруулах асуудалд анхаарлаа хандуулах нь оновчтой гарцын шийдэл болох болов уу? гэж судлаачийн зүгээс үзэж байна. Тухайлбал, гадаад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд техник технологи, тоног төхөөрөмжийн зээл тусламж, хандив, аялал жуулчлалын хүрээг батлан хамгаалах салбартай холбож зохион байгуулах гэх мэт арга замууд байж болох юм.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

- БХЭЗЧ –ын хувьд санхүүгийн чадавхи сулавтар байна.
- БХЭЗЧ –ыг эдийн засгийн бус арга замаар сайжруулах хэрэгтэй.

ЭШЛЭЛ АВСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он.
- Тунгалаг.Д, “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол практикийн зарим асуудал” 2015 он. Х46-48, ISBN 978-99973-956-1-0.
- Финасово-экономическая безопасность в условиях открытости национальной экономики
- Энх-Амгалан.Б, “Эконометрийн шинжилгээнд Evies ашиглах нь” 2016 он, х158-180, DDC-330-Э-66.
- Намсрай.Т, Нанжид.Д, “Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал” 2016 он, х55- х121, ISBN 978-99973-992-6-7.
- Нямбат. Л, “ Эдийн засгийн хэмжилзүй” тэргүүн, дэд дэвтэр- аргууд, УБ хот, 2014он, ISBN 978-99973-903-1-8.

I.дүгээр хавсралт.

Төсвийн эмзэг байдал өндөр байна.

Үзүүлэлт	Утга	Эмзэг байдал
Төсвийн тэнцэл /ДНБ	-10,2%	Өндөр
ЗГ-ын өр/ ДНБ	84%	Өндөр
Санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгцээ / ДНБ	12.2%	Өндөр
Зайлшгүй шаардлагатай зардал/ Нийт зардал	76.5%	Өндөр
Түүхий эдийн орлого/ Нийт орлого	15%	Дунд

Гадаад секторын эмзэг байдал өндөр байна.

Үзүүлэлт	Утга	Эмзэг байдал
Түүхий эдийн экспорт / нийт экспорт	84%	Өндөр
Экспорт / ДНБ	39,2%	Өндөр
Худалдааны тэнцэл/ ДНБ	12.4%	Бага
ГВАН/ Импорт	4 сар	Өндөр
Мөнгөн гуйвуулга/ДНБ	2,9%	Дунд

Санхүүгийн секторын эмзэг байдал дунд -> өндөр байна.

Үзүүлэлт	Утга	Эмзэг байдал
Гадаад валютын өр / нийт өр төлбөр	20,9%	Дунд
Өөрийн хөрөнгө / нийт актив	11.2%	Бага
Чанаргүй зээл/ нийт зээл	9%	Өндөр
Зээл / хадгаламж	154%	Өндөр
Зээл / ДНБ харьцааны өсөлт	-2.7%	Дунд

*Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн
чадавхыг сайжруулах арга зам*

Мөнгө, валютын ханшийн эмзэг байдал бага -> дунд байна.

Үзүүлэлт	Утга	Эмзэг байдал
Инфляци	-0,06%	Бага
Инфляцийн хүлээлт	-0.6%	Бага
Бодит хүү	15.06%	Бага
ГВАН/ДНБ	23.2%	Дунд
Валютын ханшийн уян хатан байдал	Зохицуулалттай хөвөгч	Дунд

Нийгмийн салбарын эмзэг байдал дунд -> өндөр байна.

Үзүүлэлт	Утга	Эмзэг байдал
Ядуурлын мэдрэмж	1.9	Өндөр
Ажилгүйдлын түвшин	10.4%	Өндөр
Өдрийн \$ 1.9-аас бага орлоготой хүн ам/ нийт хүн ам	21,6%	Дунд
Жини индекс	0,32	

ХЯТАДЫН ҮЗЭЛ САНААНЫ СУУРЬ БОЛСОН ГУРВАН БИЧИГ

*П.Бямбахорол**

Товч Агуулга: Хятад үндэстний соёл, сэтгэлгээний онцлогийг ойлгох, тайлбарлахад зайлишгүй авч үзэх зүйлсийн нэг нь хятадын боловсролын уламжлал юм. Хятад хүн буюу сэтгэлгээний онцлогийг бий болгож байгаа тэрхүү боловсролын уламжлал, тогтолцоо нь Күнзийн сургаалтай шууд холбогдох бөгөөд өнөөдөр ч гэсэн БНХАУ Күнзийн сургаал, гүн ухаанаа идэвхитэй судалж, сурталчилсаар байна. XXI зууны социалист БНХАУ Күнзийн сургаалаа илүү анхаарч байгаа нь социализмаасаа татгалзах гэж байгаа хэрэг биш, харин суурин тариалан соёл иргэнишлд нь нийцэж, түүхийн урт хугацааг даван туулж, боловсорч ирсэн үзэл санаагаа нийгэм журамтай уялдуулан “хятад онцлогтой социализм”-ыг хөгжүүлж байгаа хэрэг юм.

Abstract: One of the essential considerations in order to interpret and understand the peculiarities of Chinese culture with their unarguable perceptions in the educational inheritance of People's Republic of China. The educational inheritance and its system tend to construct the perceptions and mentality of Chinese people which are tightly connected to the teaching of Confucianism. Recently, China has been deeply and actively exploring the teaching context and philosophy of Confucius conception as well as widely expanding throughout the country. In the 21st century, taking into consideration the Confucius teaching, People's Republic of China's so-called socialist system, doesn't significantly mean not pursuing the concept of socialism, however, it might lead to developed “the Chinese peculiar socialism” by integration with social norms and rules into people's perceptions that matches its civilization of agricultural settlements and challenged the long-lasting history as well as substantially improvement of its quality.

* ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ph.D

1. ОРШИЛ:

Хятад хүний бодох сэтгэх, гэр бүл, улс орноо хэрхэн авч явж байгаа нь өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй. Хятад хүн биеэ хэт өргөдөггүй, аливаа юманд алгуур тууштай ханддаг гэх мэт. Эдгээр сэтгэлгээний онцлог буюу хятад хүнийг бий болгож байгаа нэгэн гол зүйл бол боловсролынх нь уламжлал, тогтолцоо юм байна гэж үзвэл, тэрхүү уламжлал нь Күнзийн сургаалтай шууд холбогдох бөгөөд өнөөдөр ч гэсэн БНХАУ Күнзийн сургаал, түүний үзэл санааг идэвхитэй судалж, сурталчилсаар байна.

2. ХЯТАДЫН УЛАМЖЛАЛТ БОЛОВСРОЛ БА КҮН ФҮЗЫ (孔夫子 НТӨ 551-479)

Хятадын боловсролын түүхийг авч үзэхэд Күнзийн тухай ярих хэрэгтэй болдог. Күнз (Күн Фүзы 孔夫子 НТӨ 551-479) бол одоогоос 2500 гаруй жилийн өмнө амьдарч байсан Хятадын ард түмнийг соён гэгээрүүлэх үйлсэд гавьяа байгуулсан гүн ухаантан гэдгийг бид мэднэ. “Тэрбээр Хятадын түүхэнд анхны гэгдсэн хувийн сургууль байгуулж, соёлыг хааны ордон, ихэс язгууртнуудын хүрээнээс гарган нийт ард түмний хүртээл болгох үүднээс эл сургуульдаа хүссэн хэн бүхнийг эс ялгаварлан сургаж байжээ”¹. Тухайн үед Күнзийн сургаал багш-шавь, эзэн-түшмэл, эцэг-хөвгүүний барилдлага, ёс суртахууны тухайд илүү дэлгэрч байсан бөгөөд хэдэн мянган шавьтай байсан гэсэн мэдээ бий².

Күнзийн бичгийн сургаал түүхийн урт хугацааг туулж үлдэхдээ зарим үе сэргэн мандаж, зарим үе мохон дарагдаж байв. НТӨ 220 оны орчим төр улсаа байгуулж байсан Цинь Ши хуандигийн үед Күнзийн суртлыг төрийн ёсноос халж, сүм сургуулийг нь хааж, ном бичгийг нь устгажээ. Хожим нь Цинь улс мөхөж, Хань улсын төр мандсан үеэс Күнзийн сургаал дахин сэргэж, хань үндэстэн буюу хятад үндэстний соёл боловсрол, нийгмийн харилцаа, хүн ёсны гол гүн ухаан нь болон хөгжжээ. Бүр хааны ордны түшмэдийг сонгон авах гол шалгуур болж, Күнзийн сургаалыг судлагсад нэмэгдсэнээр Күнзийн сургаалд нэвтэрхий боловсорсон төрийн түшмэд хятадын төрийг түшилцдэг болж ирсэн байна.

Күнзийн сургаал нь хятад хэл бичигтэйгээ уялдан зөвхөн хятад

¹ Я.Ганбаатар, Нангиадын сонгодог утга соёлын товчоон, Улаанбаатар, 2006, 67-р тал.

² В.Инжаннаши, Хөх судар, Улаанбаатар, 2006, товчиг толт, 41-112-р тал; Монгол хятад хавсарсан дөрвөн бичиг, Их суртахуй, Оршил 1-4-р тал.

төдийгүй өөр үндэстэн, ойр зэргэлдээ улс оронд ч дэлгэрснээр Күнзийн сургаал соёлын тодорхой хүрээ бий болжээ. Тухайлбал, газар нутаг, бичиг соёлоороо хэлхээ холбоотой явж ирсэн Солонгос зэрэг улсыг Күнзийн соёлын хүрээний улс гэдэг билээ. Манай монголчуудын хувьд тэрхүү хятад бичиг соёлын хүрээнд хил залган оршиж байсан ч өөрсдийн үндэстний дархлааг хадгалсан уламжлалт бичиг үсэгтэй, өвөрмөц онцлогтой байсаар ирсэн нь сонирхолтой. Энэ тухай, Японы эрдэмтэн Масао Онүки, “Зүүн Азийн олонх үндэстэн дээр үеэс эхлэн хятад бичиг соёлын хүчтэй нөлөөн дор байсаар ирсэн ба гагцхүү монгол үндэстэн л уг нөлөөг үл зөвшөөрснөөрөө бусдаас ялгарах өөрийн хувь шинжээ илэрхийлсээр иржээ”³ хэмээн дурдсан байна. Энэ нь суурин соёлд илүү нийцсэн үзэл онол нүүдэлчин монголчуудын хувьд төдийлөн тохирохгүй, ахуй амьдралтай нь шууд уялдан холбогдохгүй байсантай ч мөн холбоотой⁴.

Түүхийн урт хугацааны туршид хятад хүний боловсрол эзэмших зам мөр, төр ёсны гол үзэл сургаал болсоор ирсэн Күнзийн сургаалыг сүүлийн үед Хятад улсын төр засгаас ихээхэн анхаарч, улмаар хөгжүүлэх, олон улсад түгээн дэлгэрүүлэх ажил эрчимжиж байна. Күнзийн сургаалыг үзэл суртал, шашин номлол гэдэг утга агуулгаар бус, харин Хятадын уламжлалт соёл, ёс суртахуун, нийгмийн харилцааны чухал нэгэн хэлбэр гэдэг талаас нь илүү сурталчлан таниулах хандлагатай байна. Тухайлбал, 2004 оны 11 дүгээр сард Солонгос улсад хамгийн анх Күнзийн институтийг байгуулснаас хойш 2016 оны байдлаар дэлхийн 100 гаруй улс оронд Күнзийн институт нээгдэж, гол төлөв хятад хэл, хятад соёл, күнзийн сургаалын дөрвөн бичиг, таван номын⁵ тухай сургалт, судалгааны ажлыг өрнүүлэх болжээ. Монгол улсын тухайд 2008 оны 5 дугаар сард МУИС болон БНХАУ-ын Шань Дун мужийн их сургууль хамтын ажиллагаа тогтоож, “МУИС-ийн Күнзийн институт”-ийг байгуулан, үйл ажиллагаагаа явуулж байна.

Хятадын соёлын хувьсгалын үе гэгддэг коммунист нийгэм

3 Масао Онүки, Монголын үндэстэн бүрэлдэн тогтсон түүхэн явцын онцлог, Олон улсын монгол эрдэмтний IV их хурал, 1-р боть, Улаанбаатар, 1985, 136-р тал.

4

5 Дөрвөн бичиг гэдэг нь Их суртахуй, Ер дундад, Шүүмжлэл өгүүлэл, Мэнзы бичиг; Таван ном гэдэг нь Шүлэглэлт ном, Ёслолт ном, Засагт ном, Зурхайт ном, Хавар намар.